



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 5/137

Хэрлэн сум

М.Гантигмаагийн хөдөлмөрийн гэрээг
цуцалж, ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, 43 дугаар зүйлийн 43.1.1, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдаж, зарим яамдын нэр, эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан чиг үүрэг шилжсэн тул Нийгмийн бодлогын хэлтсийн Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан ажилтан Мөнгөнцогийн Гантигмааг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон хөдөлмөрийн гэрээг цуцлан, үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Зоригтбаатар Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Цэцэгсайхан Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Баяртуяа Нярав

3.М.Гантигмаагийн ажлыг зохих хууль журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Н.Зоригтбаатар)-т, холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА